



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/309

Булган сум

Гэрээ шууд байгуулах
эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV/01 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/112 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн хүн амын шүдний эмчилгээнд нэн шаардлагатай зөөврийн бор машиныг 4,400,000 (дөрвөн сая дөрвөн зуун мянга) төгрөгөөр "Оюу дент" ХХК-тай хууль, журмын хүрээнд гэрээ байгуулж, хяналт тавьж хүлээн авахыг Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т үүрэг болгосугай.

2. Санхүүжилтийг "Эрүүл мэнд" хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

3. Зөөврийн бор машиныг бүртгэлжүүлж, тайлагнахыг Нэгдсэн эмнэлэг (П.Оюунцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ

